

Барилга, хот байгуулалтын сайдын
2023 оны сарын -ны
өдрийндугаар тушаалын хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ ПАСПОРТЖУУЛАХ, АШИГЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглаж байгаа 2002 оноос өмнө баригдсан бүх төрлийн барилга байгууламжийг паспортжуулах, шинээр барьсан, ашиглаж байгаа, өргөтгөж шинэчилсэн, засварлаж тоногдсон барилга байгууламжид чанар, аюулгүй байдлын түвшингээр ашиглалтын гэрчилгээ олгох үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюулын улмаас ноцтой эвдрэл гэмтэл үүсч, хохирол учирсан барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөл байдал, аюулгүй ажиллагааг тогтоох, ашиглалтын гэрчилгээний төрлийг өөрчлөхөд энэхүү журмыг баримтална.

1.3. Ашиглагдаж байгаа барилга байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргаж баталгаажуулсан баримт бичиг нь иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг хангах, иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учруулах аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх үндэслэл болно.

Хоёр. Ашиглаж байгаа барилга, байгууламжийг паспортжуулах хүсэлт гаргах, паспортжуулалтын үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Тухайн нутаг дэвсгэрт байршилтай ашиглагдаж байгаа 2002 оноос өмнө баригдсан бүх төрлийн барилга, байгууламжийн ашиглалтад хяналт тавих, бүртгэх, паспортжуулах үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

2.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах эрх бүхий хуулийн этгээдийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангах, барилга байгууламжийн бат бэх, найдваршил зэрэг техникийн асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах үүрэг бүхий 5-аас доошгүй гишүүдээс бүрдсэн орон тооны бус паспортжуулалтын зөвлөлтэй байна. /Энэхүү журамд зааснаар орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг байгуулж болно/

2.3. Орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийг аймаг, нийслэлийн хот байгуулалт, барилга, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч дарга ахалж, зөвлөлийн бүрэлдэхүүнд барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагын дарга, тухайн байгууллагын барилгын техникийн улсын хяналтын улсын /ахлах/ байцаагч, барилгын салбарын мэргэжлийн зэрэг дэвтэй инженерийг оролцуулан байгуулна.

2.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийн дотоод үйл ажиллагааг зохицуулах журмыг баталж мөрдүүлэх ба тус

зөвлөлийн гишүүдэд цалин хөлс олгох, хүлээх хариуцлагын асуудлыг энэхүү журамд тусган хэрэгжүүлнэ.

2.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь барилга байгууламжийн бат бэх, найдваршилийн техникийн болон паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг нягтлан шалгах, хянан баталгаажуулж шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагыг шаардагдах багаж хэрэгслэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

2.6. Барилгын өмчлөгч нь барилга байгууламжийг паспортжуулах хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргад гаргана.

2.7. Журмын 1.3-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргуулах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргад гаргана.

2.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламжийг паспортжуулах ажлыг 30 хоногийн дотор зохион байгуулж паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг өмчлөгчид албан бичгээр хүргүүлнэ.

2.9. Бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй барилга байгууламжийг паспортжуулах хүсэлтийг хүлээн авсанаас хойш "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хуульд заасан хугацаанд өмчлөгчид хариу хүргүүлнэ.

2.10. Журмын 2.8 дугаар заалтад хамаарах барилга байгууламжийг паспортжуулах ажлыг зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй, эсхүл зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ.

2.11. Журмын 2.9 дэх заалтад хамаарах барилга байгууламжийг паспортжуулах ажлыг сонгон шалгаруулалтын аргаар шалгаруулж гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ.

2.12. Хуулийн этгээд нь доорх шаардлагыг хангасан байна:

2.12.1. Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг 3-аас доошгүй барилга байгууламжид хийж гүйцэтгэсэн байх,

2.12.2. Үл эвдэх аргаар судалгаа, шинжилгээ хийх багаж, тоног төхөөрөмжтэй байх,

2.12.3. Барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн хүрээнд зөвлөх инженерийн зэрэг дэвтэй, бусад төрлийн инженерүүд мэргэшсэн инженерийн зэрэг дэвтэй байх,

2.12.4. Мэргэжлийн хариуцлагын даатгалтай байх.

2.12.5. Барилгын норм дүрэм боловсруулахад оролцсон, хянан тохиолдуулсан, санал өгсөн, төсөл хэрэгжүүлсэн зэрэг туршлагатай байх.

Гурав. Барилга байгууламжид паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргаж баталгаажуулах үйл ажиллагаа

3.1. Барилга, байгууламжид паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг хуулийн этгээдийн барилга байгууламжийн бүтээцийн зураг төслийн зөвлөх инженер ахалж, барилга байгууламжид хэмжилт судалгаа хийх аргаар гүйцэтгэнэ.

3.2. Дээрх үйл ажиллагаанд "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм" БНБД 22-01-21, "Газар хөдлөлтийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар" БД 31-103-00, "Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар БД 31-101-00, "Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар" БД 31-102-00,

"Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал" БД22-105-18, "Том хавтгаалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал" БД22-107-18, "Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал" БД22-106-18, "Авто зам, гүүр, инженерийн хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал" болон холбогдох бусад норм ба дүрэм, зааврыг мөрдөнө.

3.3. Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт нь дараах хэсгээс бүрдэнэ:

3.3.1. Паспортжуулалтын зөвлөлийн даргын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан нүүр хуудас;

3.3.2. Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргасан хуулийн этгээдийн нэр, тэмдэг, зөвлөх, мэргэшсэн инженерүүдийн гарын үсэг, тэмдэг бүхий хуудас /нүүр хуудасны ар талд/;

3.3.3. Гарчиг;

3.3.4. Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах үндэслэл;

3.3.5. Барилга, байгууламжийн түүх;

3.3.6. Биет үзлэг, хэмжилтийн судалгааны үр дүнгийн тайлан

3.3.7. Үндсэн бүтээцэд хийсэн инженерийн тооцооны үр дүн;

3.3.8. Инженерийн байгууламж, шугам сүлжээний эрсдэлийн үнэлгээний үр дүн

3.3.9. Барилга, байгууламжийн ашиглалтын төлөв байдлын нэгдсэн дүгнэлт;

3.3.10. Цаашид авах арга хэмжээний санал;

3.3.11. Хавсралт материалууд: Буурь хөрсний инженер геологийн судалгааны дүгнэлт, лабораторийн шинжилгээний үр дүн, барилга, байгууламжийн гүйцэтгэлийн болон хэмжилтийн зураг төсөл, барилгын үндсэн хийц бүтээц, инженерийн байгууламж, шугам сүлжээний төлөв байдлын фото зураг, ашигласан материал, тооцооны программ хангамж, тоног төхөөрөмжийн жагсаалт, барилга байгууламжийн хувийн хэрэг, үзлэг хийгдэх үед дагалдан гарах бусад ажлын тайлан.

3.4. Барилга, байгууламжийн баталгаажуулсан паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт нь 3 эх хувь үйлдэгдэх бөгөөд нэг хувийг өмчлөгчид, үлдэх хувийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллагад хүлээлгэн өгнө.

3.5. Паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт нь барилга байгууламжийг буулгах, их засвар хийх, хүчитгэх, шинэчилж засварлах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

3.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга /эсхүл орон тооны бус паспортжуулалтын зөвлөл/ нь паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг баталгаажуулж, буулгасан барилга байгууламжийн паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг хүчингүй болгоно.

Дөрөв. Барилга, байгууламжийг паспортжуулах үйл ажиллагааны санхүүжилт

4.1. Олон нийт, иргэний барилга /сургалт хүмүүжлийн барилга, эмнэлэг, амралт, сувилал, биеийн тамир, спорт, шинжлэх ухааны барилга байгууламж/ болон 2002 оноос өмнө ашиглалтад орсон нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг паспортжуулах үйл ажиллагааны санхүүжилтийг салбарын яам, аймаг,

нийслэлийн Засаг дарга хариуцаж улсын болон орон нутгийн төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.

4.2. Журмын 4.1 дэх заалтад зааснаас бусад барилга байгууламжийг паспортжуулах үйл ажиллагааны санхүүжилтийг өмчлөгч хариуцна.

4.3. Барилга, байгууламжийг паспортжуулах үйл ажиллагаанд биет үзлэг, хэмжилтийн судалгаа, инженерийн тооцоо хийх ажлын зардлыг "Барилга байгууламжийн бат бэх, найдваржилтийн төлөв байдалд паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын жишиг үнэ" болон холбогдох бусад жишиг үнийг мөрдөнө.

Тав. Ашиглалтын гэрчилгээний төрөл, гэрчилгээ олгох үйл ажиллагаа

5.1. Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ нь ногоон, шар, улаан гэсэн төрөлтэй байна.

5.2. Өмчлөгч нь барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээг шинээр авах, дахин авах, гэрчилгээний төрлийг өөрчлүүлэх асуудлаар барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргад албан бичгээр хүсэлт гаргана.

5.3. Бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжид аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан байгууллага ашиглалтын гэрчилгээ олгоно.

5.4. Онцгой төвөгшилтэй болон улсын чанартай барилга байгууламжид барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ашиглалтын гэрчилгээг олгоно.

5.5. Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээг дараах баримт бичгийг үндэслэн олгоно:

5.5.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын /эсхүл орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийн/ баталгаажуулсан паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт;

5.5.2. Эрх бүхий байгууллагаас шинээр барьсан, өргөтгөж шинэчилсэн, засварлаж тоноглогсон ажлыг ашиглалтад оруулсан комиссын дүгнэлт;

5.6. Өмчлөгчөөс гаргасан хүсэлтийг Журмын 5.2 дахь заалтад заасан холбогдох байгууллагууд судалж, барилга, байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгох асуудлыг ажлын 7 хоногт багтаан шийдвэрлэж баталгаажуулан албан бичгээр хариу хүргүүлнэ.

5.7. Өмчлөгч нь дутуу, шаардлага хангаагүй баримт бичиг ирүүлсэн тохиолдолд хугацааг тооцохгүй бөгөөд хариуг албан бичгээр хүргүүлнэ.

5.8. Барилга байгууламжийн өмчлөгч нь өөрчлөгдсөн тохиолдолд барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээнд нэмэлт тэмдэглэл хийлгэнэ.

5.9. Журмын 1.3 дахь заалтад заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэхүү журмын 5.5.1, 5.5.2-д заасан баримт бичгийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллага барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээг дахин олгох буюу ашиглалтын гэрчилгээний төрлийг өөрчлөн олгоно.

5.10. Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ нь барилга, байгууламжийн ашиглалтын төлөв байдалтай нийцэхгүй нь тогтоогдвол дахин паспортжуулах талаар өмчлөгч нь аймаг, нийслэлийн Засаг даргад албан бичгээр санал хүргүүлнэ.

5.11. Аймаг, нийслэлийн Засаг даргын /орон тооны бус паспортжуулах зөвлөлийн/ баталгаажуулсан, дахин паспортжуулсан мэргэжлийн дүгнэлтээр барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээний төрөл нь барилга байгууламжийн бодит төлөв байдалтай нийцэхгүй нь тогтоогдвол өмчлөгчийн хүсэлтийг үл харгалзан гэрчилгээний төрлийг өөрчилнө.

5.12. Барилга байгууламж нь батлагдсан зураг төсөл, баримт бичгийн дагуу баригдсан эсэхийг тодруулах зорилгоор аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллагаас нэмэлт шалгалт хийж болно.

Зургаа. Хориглох зүйл

6.1. Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

6.2. Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс хүлээн аваагүй эсхүл паспортжуулаагүй барилга, байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгохыг хориглоно.

Долоо. Архивлах

7.1. Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээний эх хувийг өмчлөгчид олгож, хуулбар хувийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон аймаг, нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллагын архивт хадгална.

7.2. Барилга байгууламжийн баталгаажуулсан паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг барилгын хувийн хэрэгт хавсаргаж хадгална.

Найм. Бусад

8.1. Ашиглалтын гэрчилгээ олгохтой холбоотой гомдлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй, үндэслэлгүй гэж үзвэл хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэх эрхтэй.

8.2. Паспортжуулалттай холбоотой гомдлыг аймаг, нийслэлийн Засаг даргад гаргах бөгөөд энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй, үндэслэлгүй гэж үзвэл хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлэх эрхтэй.

8.3. Барилга байгууламжийн шар өнгийн гэрчилгээтэй буюу паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтээр засварлах, шинэчлэх, хүчитгэх шаардлагатай болох нь тогтоогдсон барилга байгууламжид аюулгүй байдлын түвшинг хангуулж, ногоон өнгийн гэрчилгээг авснаар ашиглалтын үйл ажиллагааг эрхэлнэ.

8.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт баталгаажсанаас хойш ажлын 30 хоногийн дотор барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ авч үйл ажиллагаа эрхэлнэ.

Ес. Хариуцлага

9.1. Энэхүү Журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага оногдуулна.

9.2. Өмчлөгч нь барилга, байгууламжийг гэрчилгээжүүлээгүй буюу барилга байгууламжийн аюулгүй байдлыг түвшингээр шар болон улаан өнгийн гэрчилгээтэй барилга, байгууламжид ашиглалтын үйл ажиллагаа эрхэлсэнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг хүлээнэ.

9.3. Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг чанаргүй, эсхүл буруу гүйцэтгэсэнээс үүсэх үр дагавар, үйл ажиллагааны холбогдох зардлыг аймаг, нийслэлийн Засаг дарга /орон тооны бус паспортжуулалтын зөвлөл/ хариуцна.

9.4. Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн үнэн зөвийг тухайн үйл ажиллагааг зохион байгуулсан байгууллага хариуцна.

-----000-----